

**БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН
2023 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨЛ**

НЭГ. МОНГОЛ УЛСЫН 2023 ОНД БАРИМТЛАХ ТӨСВИЙН БОДЛОГО

Дэлхийн нийт сүүлийн 3 жилийн хугацаанд урьдчилан таамаглах боломжгүй олон хүндрэл бэрхшээлүүдтэй тулгарлаа. Монгол Улсын Засгийн газраас 2020-2021 онуудад цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, иргэдийн эрүүл мэнд, ажлын байр, орлогыг хамгаалах төсвийн багц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүллээ.

Цар тахлын болон геополитикийн хямралын үеийн эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн төсөв, мөнгөний бодлогыг баримтална. Монгол Улсын 2023 оны төсвийн бодлогоор төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэх, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн дараах зорилтуудад чиглүүлж байна.

- ✓ Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх
- ✓ “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих
- ✓ Нөөцийн оновчтой хуваарилалт хийх
- ✓ Эдийн засгийг тогтворжуулах

Төсвийн орлогын чиглэлээр баримтлах бодлого

Ирэх 2023 онд Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд дэвшүүлсэн Боомтын сэргэлтийн ажлыг эрчимжүүлж, экспортыг нэмэгдүүлэхэд онцгой ач холбогдол өгч ажиллана. Мөн орон нутагт уул уурхайн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхийг дэмжиж, ашигт малтмалын орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, уул уурхайн төсөл хөтөлбөрөөс орон нутгийн иргэдийн хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно.

- Боомтын сэргэлтийг эрчимжүүлэн экспортоос орох төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.
- Уул уурхайн төсөл хөтөлбөрөөс орон нутгийн иргэдийн хүртэх эдийн засгийн өгөөжийг нэмэгдүүлнэ.
- Далд эдийн засгийг бууруулж, татварын суурийг нэмэгдүүлнэ.

Төсвийн зарлагын талаар баримтлах бодлого

Олон улсын байгууллагууд дэлхийн эдийн засгийн хямралт нөхцөл байдал 2024 он хүртэл үргэлжилнэ хэмээн төсөөлж байгаа энэ үед төр бүсээ чангалж, төрийн хэмнэлтийг хэрэгжүүлэн, “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг дэмжих, импортын дарамтыг сааруулах, нөөцийн оновчтой хуваарилалтаар дамжуулан макро эдийн засгийг тогтворжуулахад чиглэсэн дорвитой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Монгол улсын 2023 онд баримтлах урсгал зардлын зарчим

- Төсвийн бүх шатны байгууллага, төрийн өмчит, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийг мөрдөж, хэмнэлтийн горимд үргэлжлүүлэн ажиллана.
- Бүтээмжтэй уялдсан уян хатан цалин хөлсний шинэчлэлийг эхлүүлнэ.
- Төрийн үйлчилгээ үзүүлж байгаа зарим салбаруудад хүрэх үр дүнгийн гүйцэтгэл, үйлчилгээний чанарт нь үндэслэн санхүүжилт хуваарилах тогтолцоог үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- Хүүхдийн мөнгийг зорилтот бүлэгт чиглүүлнэ.
- Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлнэ.

Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хувьд нийгмийн болон эдийн засгийн дэд бүтцийг бий болгож, нийгмийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангах, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулахад түлхүү чиглэж ирсэн. Энэ хүрээндээ 2023 онд дараах бодлого, зарчим, эрэмбийг баримтлан төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсруулсан. Үүнд:

- Хэрэгжиж байгаа төслүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтээр эрэмбэлсний үндсэн дээр төсвийн төсөлд тусгах;
- Төсвийн ачааллыг бууруулах зорилгоор өндөр төсөвт өртөгтэй, томоохон төслүүдийг төслийн баримт бичигт үндэслэн үе шаттай, хэсэгчлэн хэрэгжүүлэх;
- Ирэх онуудад төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, техник эдийн засгийн үндэслэл, зураг төсвийг боловсруулах үйл ажиллагааг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллах;
- Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол бүхий шинэ төслүүдийг “Төр, хувийн хэвшлийн түншлэл”-ээр хэрэгжүүлэхээр төлөвлөх, хувийн хэвшлийн оролцоог дэмжих

Дэлхий нийтийг хамарсан барилгын материал, түүхий эдийн гэнэтийн үнийн өсөлтөөс үүдэлтэйгээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төслүүдийн төсөвт өртөг нэмэгдэх, хугацаандаа дуусахгүй байх эрсдэл үүссэн бөгөөд барилга, эрчим хүч, замын салбарыг хамарсан өргөн хүрээтэй үнийн өсөлтийн нөлөөг шийдвэрлэх зохицуулалтыг анх удаа хэрэгжүүлж байна.

ХОЁР. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН ОРЛОГО

Төсвийн орлогын төлөвлөлт

Төсвийн орлогын 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа төсвийн орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчны хүрээнд Сангийн яамнаас ирүүлсэн чиглэл, 2022 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, сүүлийн 6 жилийн судалгаа зэрэгт үндэслэн 2022 оны төсвөөс 2.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 29.2 тэрбум төгрөг байхаар тооцлоо.

Хувь хүний орлогын албан татвар

- Цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвараар 2022 онд 5.1 тэрбум төгрөг төлөвлөсөн ба 80.0 хувийг төр төсвийн байгууллагад ажиллагсдын цалин хөлсний орлого болон түүнтэй адилтгах орлогын албан татвараас бүрдэж байгаа бөгөөд хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 100 хувь биелэхээр байна. Төрийн албаны тухай хуулийн өөрчлөлт, цалингийн тогтолцооны шинэчлэлт, Сангийн яамнаас тооцсон суурь орлогын хүрээнд 2023 онд цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогыг хянасан суурь түвшингээр 6.0 тэрбум төгрөгөөр тооцлоо.
- ХААН банк, Төрийн банк, Хас банк банкинд хадгаламж эзэмшигч иргэдийн судалгаанд үндэслэн хадгаламжийн хүүний орлогод татвар ногдуулж хөрөнгийн орлогыг бүрдүүлэхээр 680.0 сая төгрөг төлөвлөж, сумдад хуваариллаа.
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуулиар хуулийн этгээд хувиараа бараа материал бэлтгэх, үйлчилгээ үзүүлсний орлогод 10 хувийн татвар суутган төсөвт төвлөрүүлдэг байсан ба шинэ хууль эрх зүйн орчны хүрээнд суурь орлогыг бодитойгоор тооцож 2023 оны суурь орлогыг 100 сая төгрөгөөр төлөвлөлөө.
- Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтоор 2022 онд 768 иргэнд 471.2 сая төгрөгийг олгосон. Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн өөрчлөлтөөр 2021 оноос татварын буцаан олголтоор 6.0 сая хүртэл төгрөгийг буцаан олгох боломжтой болсонтой холбогдуулан 2023 онд 600.0 сая төгрөг олгохоор тооцлоо.

Хүснэгт № 01. 2017-2022 оны хувь хүний орлогын албан татварын
буцаан олголтын судалгаа (сая.төг)

№	Үзүүлэлт	2019 гүйц	2020 гүйц	2021 гүйц	2022 гүйц	2023 төлөвлөгөө
1	Хүний тоо	1202	1213	804	768	1250
2	Олгосон дүн (сая.төг)	553,2	473.0	416.6	471.2	600.0

Хөрөнгийн албан татвар

Хөрөнгийн албан татварын орлогод үл хөдлөх хөрөнгийн албан татвар, бууны албан татвар, авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлогыг хамааруулж, нийт 2,128.7 сая төгрөгөөр төлөвлөв. Бүтцийн хувьд авч

үзвэл үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлого 1,673.7 сая төгрөг буюу 78.6 хувь, бууны албан татварын орлого 55 сая буюу 2.6 хувь, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын орлого 400.0 сая буюу 18.8 хувийг эзэлж байна. Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын өмнөх жилүүдийн өрийг барагдуулах чиглэлээр судалгаа, тооцоо гаргаж мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж байгаа тул тухайн орлогыг 20 сая төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн. Галт зэвсгийн албан татварыг цагдаагийн газрын галт зэвсгийн бүртгэлийг үндэслэн тооцоолсон. 2022 онд үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын хувь хэмжээг АИТХ-ын тогтоолоор шинэчлэн тогтоож уул уурхай үйл ажиллагаа эрхэлдэг хувь хүн, хуулийн этгээд 2 хувиар албан татварыг 2023 оноос төлөхтэй холбогдуулан энэ төрлийн орлогыг 1673.7 сая төгрөгөөр тооцож төлөвлөсөн.

Бусад татвар, төлбөр хураамж

Төрийн эрх бүхий байгууллагаас “Улсын тэмдэгтийн хураамжийн тухай” хуульд заасан үйлчилгээ үзүүлсний төлөө иргэн, хуулийн этгээдийн төлж байгаа тэмдэгтийн хураамжийн сүүлийн 5 жилийн гүйцэтгэлд үндэслэн 190.0 сая төгрөгөөр тооцов.

Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн хураамжийн орлогыг босоо тэнхлэгийн авто замын ажлын эрчим, бусад нөхцөл байдлыг харгалзан 70 сая төгрөгөөр төлөвлөлөө.

2023 оны хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоосон үнэлгээг харгалзан, сумын төвийн өрхийн 80.0 хувиар тооцон 170.0 сая төгрөгөөр төлөвлөв. Цаашид сумын Засаг дарга түүний тамгын газрын холбогдох албан тушаалтнууд “Хог хаягдлын тухай” хуулийн дагуу хогны менежментийг боловсронгуй болгон айл өрх, албан байгууллагуудаас авах хог хаягдлын хураамжийн орлогыг нийгэм эдийн засгийн нөхцөл байдалд нийцүүлэн тухайн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шинэчлэн батлуулан тогтоож мөрдөх шаардлагатай байна.

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн хуралдаанаар батлагдсан “Газрын төлбөрийн бааз” болон “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-д тусгасны дагуу газрын төлбөрийн орлогыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газартай хамтран тооцож 969.7 сая төгрөгийг тус орлогын төлөвлөгөөнд тусгалаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тушаалын дагуу ойгоос бэлтгэж ашиглах хэрэглээний мод бэлтгэх хуваарийг үндэслэн 2023 оны ойн нөөц ашигласны төлбөр өсч 550.0 сая төгрөгөөр төлөвлөлөө. Мөн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 2022 оны хүлээгдэж байгаа гүйцэтгэл гадаадын аялал жуулчлалын урсгал нь коронавирус өвчнөөс шалтгаалан багасах, ангийн зөвшөөрлийн эрхийн бичгийн олголт зэргийг харгалзан 7.0 сая төгрөг болгон төлөвлөлөө.

Ус ашигласны төлбөрийн орлогыг 15.3 тэрбум төгрөгөөр төлөвлөж байна. Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь байгаль экологид үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, газрын гүний усны хэрэглээг хязгаарлах, гадаргын буюу “саарал” усыг

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд түлхүү ашиглах бодлого барьж байгаа, мөн Сангийн яаманд хянуулсан 2023 оны орлогын тооцоолол зэргийг харгалзан тооцож төлөвлөсөн болно.

Хүснэгт №02. Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийн ашигладаг усны төлбөрийн орлогын судалгаа (сая.төг)

Үзүүлэлт	2018 гүйц	2019 гүйц	2020 гүйц	2021 гүйц	2022 ХБГ
Төлбөрийн дүн /мян.төг/	14,328.9	12,300.0	13,398.8	16,440.9	16,258.0

Татварын бус орлого

2023 оны аймаг, сумын төсвийн орлогод татварын бус орлогоор 2.6 тэрбум төгрөг төлөвлөснөөс торгуулийн орлогоор 900 сая, түрээсийн орлогоор 15.0 сая, торгуулийн орлого 151.2 сая, бусад орлогоор 200.0 сая, газрын дуудлага худалдааны орлого 150.0 сая, төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогоор 30.0 сая төгрөг оруулахаар төлөвлөлөө. Дээрх орлогуудыг өмнөх зургаан жилийн төлөвлөгөө, гүйцэтгэлд үндэслэн тооцсон болно. Нэмж тооцогдож байгаа орлого Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн хүүгийн орлого буюу Булган аймагт хэрэгжүүлсэн дэд бүтцийн төслүүдийн эргэн төлөлтийн орлогоос тооцогдох дүн бөгөөд Сангийн яамнаас өгсөн чиглэлийн дагуу 2023 онд 1,356.6 сая төгрөгөөр тооцосон болно.

ГУРАВ. БУЛГАН АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДАЛ

Төсвийн зарлагын талаар

Орон нутгийн төсвийн байгууллагын төсвийг Сангийн яамнаас хянасан суурь зардал, сүүлийн жилүүдийн төсвийн гүйцэтгэл, 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд үндэслэн тооцооллыг хийлээ.

2023 оны төсвийн жилд төсвийн урсгал зарлагатай холбоотой дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг төр, төсвийн бүх байгууллагууд хэрэгжүүлэн ажиллана.
- Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлсэн зээлийн эргэн төлөлтөд 834.2 сая төгрөг, зээлийн хүүгийн төлбөрт 1,356.6 сая төгрөг нийт 2,190.8 сая төгрөгийг төвлөрүүлэхээр болсон.
- Мэргэжлийн хяналтын ерөнхий газар татан буугдаж байгаатай холбоотой аймгийн Засаг даргын Тамгын газарт байгаль орчин, геологи уул уурхай, авто зам, авто тээвэр, эрчим хүчний хяналтын улсын байцаагчийн нийт 6 орон тоо шилжиж ирж байгаатай холбоотой эдгээр төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг тусгасан.
- Аймгийн Эрчим хүчний зохицуулах хорооны тогтоолын дагуу 11 сумын дулааны тариф нэмэгдсэнийг суурь зардалд нэмэгдүүлэн тооцсон.
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу орон нутгийн суурь зардалд тусгагдсан улсын төсвийн байгууллагуудын байр ашиглалтын зардлын тооцооллыг хийж тусгасан.
- Төрийн албаны цалингийн тогтолцооны шинэчлэлийг тусгасан. Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг хөдөлмөрийн хөлсний доод түвшинтэй уялдуулан 6 хувиар нэмэгдүүлж, төрийн захиргааны болон төрийн тусгай албан хаагчдын үндсэн цалинг нэг шатлалд шилжүүлж, төрийн захиргааны албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 20%-ийг тооцож тусгасан.
- Төрийн албаны тухай хуулийн тухай тэтгэвэрт гарах 16 төрийн албан хаагчид нийт 316.3 сая төгрөгийн тэтгэмжийг Төрийн албаны тухай хуулийн дагуу тооцож тусгасан.
- Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан ИТХ төлөөлөгчдөд сар бүр олгох урамшуулал нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалттай зөрчилдөж байгаа тул ЗГХЭГ-аас уг журмын урамшуулалтай хэсгийг хасахаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байгаа тул аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн урамшууллын зардлыг тусгаагүй болно.
- Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу ээлжит сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн 15 улс төрийн албан хаагчдын (Багийн Засаг дарга) нөхөн олговорт нийт 56.8 сая төгрөгийг тусгасан.

- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаалаар дотоод албан томилолтын зардлын тариф шинэчлэгдэн батлагдсан. Үүнтэй холбоотой дотоод албан томилолтын зардлыг Төрийн хэмнэлтийн тухай хууль, Сангийн сайдын тушаалд нийцүүлэн тооцооллыг хийсэн.
- Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын дагуу “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-д заасны дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг сумын суурь зардалд тусгасан. 16 суманд 629.3 сая төгрөг хуваарилагдаж байгаа бөгөөд сумын суурь орлогод тооцогдсон ойгоос түлээ, мод бэлтгэж ашигласны төлбөр, ус ашигласны төлбөр, газрын төлбөр, ан амьтан барих зөвшөөрлийн хураамж, байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлогоос хамаарч 0.3-103.0 сая төгрөг тооцогдож байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаас суурь зарлага санхүүжүүлэхгүй болсонтой холбоотой мал эмнэлгийн үйлчилгээний хөлс болон хот тохижилтын үйлчилгээний хөлсийг орон нутгийн төсвөөс санхүүжих суурь зарлагад тооцож тусгасан.
- Аймгийн төсвөөс санхүүжих орон нутгийн төсвийн байгууллагуудын төсвийг өмнөх жилүүдийн гүйцэтгэл, шинээр батлагдан гарах хууль, журмын хүрээнд боловсрууллаа.

Хүснэгт №03. Аймгийн шууд харьяа байгууллагуудын төсвийн тооцоо

(мянган төгрөг)

Д/д	Байгууллагын нэр	2023 оны төсвийн төсөл
1	Аймгийн ИТХ	729,245.9
2	Аймгийн ЗДТГ	3,246,621.2
3	Санхүүгийн хяналт, аудитын алба	207,361.0
4	Орон нутгийн Өмчийн газар	173,819.9
5	Байгаль орчин аялал жуулчлалын газар	750,741.5
6	Хүүхдийн сувилал	196,366.1
7	Хотын нийтийн хүн тээвэр	10,000.0
8	Халамжийн сан	110,880.0
9	Гамшгаас хамгаалах сан	100,000.0
10	Цэргийн дүйцүүлэх алба	170,000.0
11	Цэвэрлэх байгууламж	364,935.6
12	Малын эрсдэлээс хамгаалах сан	100,000.0
13	Дамжуулан олгосон зээлийн төлбөр, хүүгийн төлбөр	2,190,824.5
14	Ахмадын хороо	95,333.7
15	Нөөцийн махны урамшуулал	25,000.0
16	Мал эмнэлгийн үйлчилгээ	627,865.0
17	Улсын төсвийн байгууллагын байр ашиглалтын зардал	1,300,505.2
	Нийт дүн	10,399,499.6

Суманд олгох санхүүгийн дэмжлэг

Суурь зардалд орон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, ойн анги, тохижилт үйлчилгээний ангийн зардал, байр ашиглалт болон үйлчилгээний зардлыг тооцоолсон. 2023 оны төсвийн жилд 11 сумын дулааны эрчим хүчний тариф аймгийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн тушаалаар шинэчлэгдэн батлагдсан.

Суманд олгох санхүүгийн дэмжлэгийг суурь зардал, суурь орлогын зөрүүгээр тооцоолсон ба 13 сум, 1 тосгонд 10,238.3 сая төгрөгийг олгож, 3 сумаас 1,120.4 сая төгрөгийг төвлөрүүлж авахаар тооцогдож байна.

Хүснэгт №04. 2023 оны суманд олгох санхүүгийн дэмжлэг

(мянган төгрөг)

№	СУМЫН НЭР	СУУРЬ ЗАРДАЛ	СУУРЬ ОРЛОГО	САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ
1	Баян-Агт	1,122,735.0	286,525.3	836,209.8
2	Баяннуур	759,555.0	202,288.1	557,266.9
3	Бугат	931,388.3	245,867.9	685,520.4
4	Гурванбулаг	927,898.9	265,821.6	662,077.4
5	Дашинчилэн	932,913.4	281,830.7	651,082.7
6	Могод	955,536.2	257,430.6	698,105.6
7	Орхон	954,383.0	322,107.3	632,275.7
8	Рашаант	1,171,509.8	439,849.7	731,660.1
9	Сайхан	942,886.7	240,443.3	702,443.5
10	Сэлэнгэ	1,337,694.8	403,275.2	934,419.7
11	Тэшиг	1,216,043.8	592,974.9	623,068.9
12	Хишиг-Өндөр	1,118,682.6	308,100.7	810,581.8
13	Хутаг-Өндөр	1,609,624.9	679,597.9	930,027.0
14	Хялганат	1,175,403.7	391,865.5	783,538.2
	Сумын төсвийн дүн	15,156,256.1	4,917,978.6	10,238,277.6

Хүснэгт №05. 2023 онд сумаас аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ

(мянган төгрөг)

№	СУМЫН НЭР	СУУРЬ ЗАРДАЛ	СУУРЬ ОРЛОГО	ТӨВЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО
1	Булган	3,720,829.4	4,070,257.1	349,427.7
2	Бүрэгхангай	1,033,987.5	1,104,748.3	70,760.8
3	Хангал	874,214.6	1,664,387.1	790,172.5
	Дүн	5,629,031.5	6,839,392.4	1,210,361.0

Орон нутгийн хөгжлийн сан

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг 7,525.8 сая төгрөгөөр батлагдсан нь өмнөх оноос 24 хувиар буюу 1,459.2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Ирэх онд уул уурхайн экспортын хэмжээ нэмэгдэх хүлээлттэй байгаагаас шалтгаалж ашигт

малтмалын нөөц ашигласны төлбөр болон газрын тосны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ нэмэгдэж байгаа нь ОНХС-ийн орлогын шилжүүлгийн хэмжээ нэмэгдэхэд голлон нөлөөлж байна.

Төсвийн тухай хуульд өөрчлөлт орж 2023 оны төсвийн жилээс орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс суурь зарлага буюу хот тохижилт, мал эмнэлгийн үйлчилгээний хөлсийг санхүүжүүлэхгүй болсон.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас хуваарилагдсан 7,525.8 сая төгрөгөөс Тогтвортой амьжиргаа-3 төслийн дэмжлэг, урамшуулал, нэр заагдсан сумдын ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг хасаж, итгэлцүүрээр хуваарилагдах хөрөнгийн 50 хувь болох 3,389.7 сая төгрөгийг сумын хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хуваарилсан.

Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий 10 суманд 245.6 сая төгрөг, Тогтвортой амьжиргаа-3 төслийн дэмжлэг, төслийн урамшуулал авах нөхцөл хангасан 6 суманд 255.1 сая төгрөг олгож, итгэлцүүрт үндэслэн хуваарилахад суманд дунджаар 129.9-462.3 сая төгрөг ногдож байна.

Хүснэгт №06. 2023 оны сумын орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн тооцоолол

(мянган төгрөг)

№	СУМ	Итгэлцүүрт үндэслэсэн хуваарилалтын дүн	ТА-3 төслийн урамшуулал	АМ-ын хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр /50%/	АМ-ын ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр /50%/	Сумдад хувиарлагдах
1	Баян-Агт	218,304.5				218,304.5
2	Баяннуур	114,297.5	20,194.9	1,704.1	1,360.8	137,557.3
3	Бугат	129,138.5			762.5	129,901.0
4	Булган	282,512.2				282,512.2
5	Бүрэгхангай	174,386.1		23577.85	64,776.3	262,740.2
6	Гурванбулаг	201,295.0	35,002.2		663.7	236,960.9
7	Дашинчилэн	188,019.6	33,083.3		33,573.4	254,676.3
8	Могод	173,504.9		25.1		173,530.0
9	Орхон	173,927.3			81,451.9	255,379.2
10	Рашаант	203,469.2		5,711.8		209,181.0
11	Сайхан	193,780.6			2,418.0	196,198.5
12	Сэлэнгэ	245,306.8			11,537.0	256,843.8
13	Тэшиг	382,316.1	67,922.5		12,056.9	462,295.5
14	Хангал	215,814.7	39,212.3			255,027.0
15	Хишиг-Өндөр	151,245.4		5,968.6	49.1	157,263.1
16	Хутаг-Өндөр	342,414.3	59,695.6			402,109.9
	НИЙТ ДҮН	3,389,732.8	255,110.8	36,987.5	208,649.6	3,890,480.6

Суманд орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгээр нийт 3,890.5 сая төгрөгийг олгож, аймгийн орон нутгийн хөгжлийн санд 3,635.4 сая төгрөг хуваарилагдах тооцоолол хийгдсэн.

**Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт,
хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт**

(мянган төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр байршил, хүчин чадал	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
1. Шилжих хөрөнгө оруулалт				100,000.0	100,000.0
1.1	Хяналтын камерын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хэсэгчлэн шинэчлэх (Булган сум)	2022	2023	50,000.0	50,000.0
1.3	Орон нутгийн өмчийн барилга байгууламж шинээр барих (Хутаг-Өндөр сум)	2023	2023	50,000.0	50,000.0
2. Барилга байгууламж, дэд бүтэц				2,434,948.4	2,434,948.4
2.1	Аймгийн төвийн гэрэлтүүлэг, гэрлэн чимэглэлийн хэмжээг нэмэгдүүлэх (Булган сум)	2023	2023	700,000.0	700,000.0
2.2	Сумын төвийн гэрэлтүүлэг (Рашаант сум)	2023	2023	70,000.0	70,000.0
2.3	Нийтийн биеийн тамирын талбай байгуулах (Булган сум)	2023	2023	500,000.0	500,000.0
2.4	Халуун усны барилга шинээр барих (Гурванбулаг сум)	2023	2023	177,000.0	177,000.0
2.5	Төрийн албан хаагчийн орон сууц барих (Хангал сум, Хялганат тосгон)	2023	2023	300,000.0	300,000.0
2.6	Сумын төвийн гэрэлтүүлэг (Бугат сум)	2023	2023	100,000.0	100,000.0
2.7	Явган болон дугуйн зам шинээр барих (Булган сум, 2490 м)	2023	2023	520,948.4	520,948.4
2.8	Сумын ЗДТГ-ын барилгын гадна фасадны ажлын өөрчлөлтийн үнийн санхүүжилт (Баян-агт сум)	2023	2023	67,000.0	67,000.0
3.Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл				417,900.0	417,900.0
3.1	Аймгийн төвийн хяналтын камерыг өргөтгөх, шинэчлэх	2023	2023	100,000.0	100,000.0
3.2	Аймгийн Музейн камерын хүчин чадлыг нэмэгдүүлэх	2023	2023	20,000.0	20,000.0
3.3	Төрийн албаны цахим шилжилт-Ухаалаг Булган цахим системийг нэвтрүүлэх	2023	2023	138,400.0	138,400.0
3.4	Хөгжимт жүжгийн театрын тохижилт, техник хэрэгслийн шинэчлэл	2023	2023	100,000.0	100,000.0
3.5	Усан бассейн сургалтын төвд усны тоос сорогч	2023	2023	7,500.0	7,500.0
3.6	Соёл, урлагын газрын компьютер, техник хэрэгсэл	2023	2023	7,000.0	7,000.0
3.7	Гамшгаас хамгаалах салбарын автомашин (Хутаг-Өндөр сум)	2023	2023	45,000.0	45,000.0
НИИТ				2,952,848.4	2,952,848.4

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалт

(мянган төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
1. Шилжих их засвар:				936,644.2	536,644.2
1.1	Сургуулийн спорт заалны дээврийн засварын ажил (Баяннуур сум)	2022	2023	80,000.0	80,000.0
1.2	АЗДТГ-ын "Г" блокын засварын нэмэлт ажил	2022	2023	10,621.0	10,621.0
1.3	Сургуулийн барилгын засвар (Сэлэнгэ сум)	2022	2023	496,023.2	246,023.2
1.4	Соёлын төвийн засвар (Сэлэнгэ сум)	2022	2023	350,000.0	200,000.0
2. Шинээр хэрэгжих их засвар				1,570,000.0	1,570,000.0
2.1	Цэцэрлэгийн барилгын засвар (Дашинчилэн сум)	2023	2023	300,000.0	300,000.0
2.2	Сургуулийн барилгын засвар (Хангал сум)	2023	2023	200,000.0	200,000.0
2.3	Биеийн тамир спортын газрын "Б" заалны засвар	2023	2023	250,000.0	250,000.0
2.4	Соёлын ордны барилгын их засвар (Булган сум)	2023	2023	150,000.0	150,000.0
2.5	Бугат сумын ЗДТГ-ын барилгын засвар	2023	2023	300,000.0	300,000.0
2.6	Сургуулийн барилгын засвар (Бүрэгхангай сум)	2023	2023	350,000.0	350,000.0
2.7	Мобикомын дамжуулах станцын хашаа (Хутаг-Өндөр сум, Хантай баг)	2023	2023	20,000.0	20,000.0
Нийт дүн				2,506,644.2	2,106,644.2

Аймгийн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалт

(мянган төгрөг)

№	Төсөл арга хэмжээний нэр байршил, хүчин чадал	Хамрах салбар	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
1. Шилжих төсөл, арга хэмжээ					799,305.4	599,305.4
1.1	Ахуйн үйлчилгээний барилгын засварын 2 дахь шатны ажил (Гурванбулаг сум)	Нийгмийн салбар	2023	2023	100,000.0	100,000.0
1.2	Орон нутгийн өмчийн барилга, байгууламж барих (Сайхан сум)	Нийгмийн салбар	2022	2023	280,000.0	280,000.0
1.3	Соёлын төвийн засвар (Баяннуур сум)	Соёл	2022	2023	419,305.4	219,305.4
2. Шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ					3,954,064.4	3,011,064.4
2.1	Хөрөнгө оруулалтын ажлын зураг, төсөл, ТЭЗҮ боловсруулах	Дэд бүтэц	2023	2023	522,300.0	522,300.0
2.2	Өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх	Хөдөө аж ахуй	2023	2023	150,000.0	150,000.0
2.3	Аймгийн баяр наадмын зардал	Нийгмийн салбар	2023	2023	80,000.0	80,000.0
2.4	Сумын төвийн цахилгаан хангамжийн 0.4-10 кв-ын ЦДАШ-ын шинэчлэл (Баяннуур сум)	Дэд бүтэц	2023	2023	280,000.0	280,000.0
2.5	Сумын төвийн гудамж, зам талбайн тохижилт (Булган сум)	Дэд бүтэц	2023	2023	250,000.0	250,000.0
2.6	Сумын төвийн цахилгаан хангамжийн засвар, шинэчлэл (Баян-Агт сум)	Дэд бүтэц	2023	2023	80,000.0	80,000.0
2.7	"Монгол баялаг 330" цуврал нэвтрүүлэг төсөл (15 сум)	Соёл	2023	2023	73,200.0	73,200.0
2.8	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, нийтийн орон сууцнуудыг ээлж дараатай халуун усны системд холбох (Булган сум)	Дэд бүтэц	2021	2024	1,443,000.0	500,000.0
2.9	Барилга байгууламжийн гэрчилгээжүүлэлт	Дэд бүтэц	2023	2023	60,000.0	60,000.0
2.10	Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах (Рашаант сум)	Дэд бүтэц	2023	2023	60,000.0	60,000.0
2.11	Сургуулийн халуун усны барилга засварлах (Хутаг-Өндөр сум Хантай баг)	Нийгмийн салбар	2023	2023	63,000.0	63,000.0
2.12	Нийтийн эзэмшлийн орон сууцны фасадны засвар (Булган сум)	Дэд бүтэц	2023	2023	350,000.0	350,000.0
2.13	Гудамж, зам талбайн гэрэлтүүлэг (Булган сум 4 дүгээр баг)	Дэд бүтэц	2023	2023	150,000.0	150,000.0
2.14	Эрүүл мэндийн зам шинээр барих (Булган сум)	Дэд бүтэц	2023	2023	392,564.4	392,564.4
3. Бараа, тоног төхөөрөмж					25,000.0	25,000.0
3.1	Гэр цэцэрлэгийг шинэчлэх 5 ш	Нийгмийн салбар	2023	2023	25,000.0	25,000.0
НИЙТ					4,778,369.8	3,635,369.8

**Авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр,
төсөл арга хэмжээний жагсаалт**

(мянган төгрөг)

Д/д	Төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		2023	2023		
1	Ургац тээврийн авто замын засвар	2023	2023	60,000.0	60,000.0
2	Орон нутгийн чанартай авто замын засвар, арчлалт	2023	2023	60,000.0	60,000.0
3	Байгалийн гамшгийн үеийн авто зам, замын байгууламжийн засвар	2023	2023	50,000.0	50,000.0
4	Булган сумын төвд нийтийн эзэмшлийн авто зогсоолын талбайг нэмэгдүүлэх (11-р байр)	2023	2023	80,000.0	80,000.0
5	Зам, тээврийн хяналтын төвийн зардал	2023	2023	15,000.0	15,000.0
6	Сумын төвийн зам засвар (Рашаант сум)	2023	2023	100,000.0	100,000.0
7	Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих (Бугат сум)	2023	2023	250,000.0	250,000.0
8	Сумын төвийн хатуу хучилттай авто зам барих (Орхон сум)	2023	2023	250,000.0	250,000.0
	Нийт дүн			865,000.0	865,000.0

**Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар
хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт**

(мянган төгрөг)

Д/д	Хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, тоо хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Төсөвт өртөг (мян.төг)	2023 онд санхүүжих дүн (мян.төг)
Шилжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ				
1	Хангал сумын цэвэр усны даралтат цамхаг барих	2022-2023	250,000.0	250,000.0
2	Булаг шандын эхийг хашиж хамгаалах (Баян-Агт, Орхон, Хишиг-Өндөр, Баяннуур, Булган, Бүрэгхангай, Дашинчилэн, Могод, Гурванбулаг сум)	2022-2025	68,000.0	68,000.0
Дүн			318,000.0	318,000.0
1. Усны нөөц хамгаалах, усан хангамжийг сайжруулах чиглэлээр				
3	Булаг шандны эхийг хашиж хамгаалах (Баян-агт, Бугат, Бүрэгхангай, Гурванбулаг, Могод, Орхон, Сайхан, Тэшиг, Хишиг-Өндөр, Хутаг-өндөр)	2023-2023	123,803.4	123,803.4
4	Хөв цөөрөм байгуулах (Могод сум)	2023-2023	231,900.7	231,900.7
5	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд усны эх үүсвэрийг бий болгох зорилгоор нуурыг нөхөн сэргээх зураг төсөв (Баяннуур сум Баян, Могод сумын Загаст)	2023-2023	70,000.0	70,000.0
6	"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд ойжуулалт (100 га, Бугат, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр)	2023-2023	356,000.0	356,000.0
7	Усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор ойн хортны судалгааны ажил (500000 га, ой бүхий сумдад)	2023-2023	40,000.0	40,000.0
8	Даралтат цамхагийн насос суурилуулах (Баян-агт сум)	2023-2023	25,000.0	25,000.0
9	Усны эхийг бүрдүүлэгч ойн санг хамгаалах зорилгоор ойн хортны тэмцлийн ажил (25000 га, Баян-Агт, Бугат, Бүрэгхангай, Орхон, Сэлэнгэ, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр)	2023-2023	748,731.5	748,731.5
10	Усны эхийг бохирдуулагч хог хаягдлыг тээвэрлэх зориулалтын тоноглогдсон автомашин (Баяннуур, Бүрэгхангай, Орхон, Сайхан, Сэлэнгэ, Булган сум)	2023-2023	360,000.0	360,000.0
11	Гэр хорооллын айл өрхүүдийг төвлөрсөн дэд бүтэц, инженерийн шугам сүлжээнд холбох (Булган сум)	2023-2023	300,000.0	300,000.0
12	Цэвэрлэх байгууламж шинээр барих (Сайхан сум)	2023-2024	691,348.8	400,000.0
13	Хүн ам, бэлчээрийн усан хангамж таримал ойн услагаа арчилгаа нэмэгдүүлэх зориулалтаар шинээр худаг гаргах (Баян-Агт, Баяннуур, Бугат, Гурванбулаг, Могод, Рашаант, Хутаг-Өндөр, Дашинчилэн,	2023-2023	270,000.0	270,000.0

	Сайхан, Хишиг-Өндөр сум)			
14	Усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг тэмдэгжүүлэх (сав газрууд)	2023-2023	49,000.0	49,000.0
15	Бүрэгхангай сумын цэвэр усны даралтат цамхаг барих 2-р шатны ажил	2023-2023	250,000.0	250,000.0
16	Орхон сумын цэвэр усны даралтат цамхаг барих 2-р шатны ажил	2023-2023	200,000.0	200,000.0
17	Бохир соруулах тоноглогдсон автомашин (Тэшиг сум)	2023-2023	80,000.0	80,000.0
18	Нефтээр бохирдсон газрын усны судалгаа, шинжилгээний зардал	2023-2023	8,000.0	8,000.0
19	Хануй, Цагаан голын орчмын хог хаягдлыг ландфиллын аргаар дарах (Баян-Агт сум)	2023-2023	30,000.0	30,000.0
Дүн			3,833,784.4	3,542,435.6
2. Ой, цөлжилтийн талаар:				
20	"Тэрбум" мод үндэсний хөдөлгөөний хүрээнд доройтсон газрыг нөхөн сэргээх ойн зурвасын ажил (4га, Дашинчилэн, Баяннуур сум)	2023-2023	90,000.0	90,000.0
21	"Хожуул" төслийг хэрэгжүүлэх (Бугат, Хангал, Орхон, Хишиг-Өндөр, Сэлэнгэ сум)	2023-2023	75,000.0	75,000.0
22	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, зам талбайн засвар арчлалт	2023-2023	100,000.0	100,000.0
23	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сургалт (2 удаа)	2023-2023	5,000.0	5,000.0
24	Бэлчээрийн хортон мэрэгчидтэй байгаль орчинд халгүй аргаар тэмцэх (40000 га)	2023-2023	64,000.0	64,000.0
25	Хөл газрын ургамалтай механик аргаар тэмцэх (Булган сум)	2023-2023	12,600.0	12,600.0
26	Байгаль орчинд ээлтэй шахмал түлшний үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулах	2023-2023	70,000.0	70,000.0
27	Байгаль орчинд ээлтэй шахмал түлшний үйлдвэрийн хашаа барих	2023-2023	110,000.0	110,000.0
28	Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны байгууллагуудтай ой хээрийн түймэр, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтарч ажиллах	2023-2023	20,000.0	20,000.0
Дүн			546,600.0	546,600.0
3. Газар, газрын хэвлийг хамгаалах, орчны бохирдлыг бууруулах хог хаягдлыг багасгах талаар				
29	Хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аяныг зохион байгуулах	2023-2023	34,000.0	34,000.0
30	Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга хэмжээ явуулах	2023-2023	5,000.0	5,000.0
31	Сумдын газар зүйн нэрийн тодруулалт, баталгаажуулах ажил (Баян-Агт, Булган, Гурванбулаг, Дашинчилэн, Орхон, Тэшиг, Хангал, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр)	2023-2024	444,295.0	230,000.0
Дүн			483,295.0	269,000.0
4. Биологийн төрөл зүйлийг хамгаалах				
32	Тусгай хамгаалалттай газар нутагт биотехникийн арга хэмжээ авах (Зэд-	2023-2023	15,000.0	15,000.0

	Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газар, Хөгнө-Тарны тусгай хамгаалалттай газар)			
	Дүн		15,000.0	15,000.0
	5. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд			
33	Олон улсын ITM үзэсгэлэнд оролцож, аялал жуулчлалын аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажиллах	2023-2023	10,000.0	10,000.0
34	Аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах (Айраг фестиваль, Хангинахын шугуйн шагайн тойром, Airagday арга хэмжээ)	2023-2023	150,000.0	150,000.0
35	Аялал жуулчлалын цахим платформ хөгжүүлэх	2022-2023	80,000.0	80,000.0
	Дүн		240,000.0	240,000.0
	6. Бусад			
36	Байгаль хамгаалах сангийн үйл ажиллагааны зардал	2023-2023	5,000.0	5,000.0
37	Байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардал	2023-2023	300,000.0	300,000.0
37	Байгаль орчны багц хуулийн хэрэгжилтийг хангах хяналт шалгалт хийх, тооллого судалгааны ажил явуулах (хууль бус мод бэлтгэл, ой, хээрийн түймэр, ан агнуур, хог хаягдал, ус, рашаан нөөц ашиглах, ашигт малтмалын чиглэлээр)	2023-2023	20,000.0	20,000.0
	Дүн		325,000.0	325,000.0
	Нийт дүн		5,761,679.4	5,256,035.6